

Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх,
зохистой ашиглах бодлогын чиглэлийн тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар Монгол орны хязгаарлагдмал усны нөөцийг хамгаалж, хомсдлоос сэргийлж, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж хүн амын унд, ахуйн ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг тасралтгүй, хүртээмжтэй хангах нөхцөл бүрдүүлэх асуудал нэн чухал болохыг тэмдэглэж, ҮАБЗ-ийн Ажлын хэсгийн боловсруулсан Усны нөөцийн хомсдлоос сэргийлэх, нөөцийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

1. Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг тодорхойлсон Усны нөөцийн стратегийн зарчим боловсруулж батлах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Устай холбоотой аливаа шийдвэр гаргах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан Усны нөөцийн стратегийн зарчмыг баримтлах;

2. "Ус" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч, цаашид үр ашигтай байхаар зохион байгуулах.